

*Д.Булган-ДХИС-ийн Удирдлагын академийн Удирдахуйн ухааны
профессорын багийн ахлах багш,
доктор, дэд профессор
цагдаагийн дэд хурандаа
Б.Уранчимэг-Магистр, судлаач*

ОРЧНЫ ЗАГВАРЧЛАЛААР ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН МЭН ЧАНАР

Хураангуй: Орчны загварчлалаар гэмт хэрэг гарах боломжийг багасгахад барилга, байгууламж, байшингийн загвар, хэлбэрийг ашиглах боломжтой гэсэн санаан дээр тулгуурладаг. Үүрх хэлбэл, тухайн газар нутаг дахь орчинд тохирсон загварчлалаар урьдчилан сэргийлэх, архитектурын загвар болон орон зайн менежментийн үзэл баримтлалд тулгуурладаг. Энэхүү үзлэлд орчны загварчлалаар гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх ажлын онол, судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан судалж, холбогдох нэр томъёо, төрлийн агуулга, бүрэлдэхүүн хэсгийн зааг ялгааг гаргаж, МУ-ын үндсний байдлыг тоймлон судаллаа.

Удиртгал. Нийгэм, эдийн засгийн хурдацтай зөрчлөлт, шинэчлэлтийн энэ цаг үед гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх ажлын бодлого, чиглэл тодорхой хэмжээгээр зөрчлөгдөж, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, гадаад улс орнуудын туршлагыг нэвтрүүлэх, төрөнтэй холбоотой судалгааны ажлыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага үндснийг хуртэл байсаар байна. Иймээс энэхүү сэдвийг дараахь үндэслэлээр судаллаа.

Монгол Улсад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” 1997 онд анх батлагдсанаас хойш 22 жилийн дараа “Гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх тухай хууль” 8 бөмөр, 48 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх арга зам, бодлогын нэгдмэл байдлыг тодорхойлж, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн.

“Гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.2.9-т “хот, тосгоны төлөвлөлтийн үйл ажиллагаанд гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх нөхцөл, нийтлэг шаардлагыг хангах” талаар заасан. Энэ заалтаас харахад гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх ажлыг хот тосгоны төлөвлөлтийн үйл ажиллагаатай уялдуулж, иргэд, оршин суугчдын аюулгүй, амар тайван амьдрах бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалт байна. Тиймээс МУ-д орчны загварчлалаар гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх талаар онолын судалгааг хөгжүүлэх, практик хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Энэхүү үзлэлийн зорилго нь орчны загварчлалаар гэмт хэрэг, зөрчлөлс урьдчилан сэргийлэх ажлын онол, судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан

судалж, холбогдох нэр томьёо, түүний агуулга, бэрэлдэхийн хэсгийн зааг ялгааг гаргаж, судалгааны эргэлтэд оруулах, хөгжүүлэх, практикт хэрэгжүүлэх боломж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэх явдал юм.

Индсэн хэсэг. Бүтээн байгуулагдсан тухайн орчны зураг төсөл нь гэмт хэрэг, зөрчлийн гаралтад нөлөөлдөг гэсэн санаа нь 1961 оноос эхлэн Жейн Жейкобс “Америкийн хотуудын хэл ба амьдрал” номоо хэвлүүлснээс хойш судлагдаж эхэлсэн¹. Жейкобс газар ашиглалтын байдал, барилгын онцлог шинж (барилгын хэлбэр, хэмжээ, урт болон бусад шинж чанар) нь тухайн орчинд гэмт хэрэг, зөрчил гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой гэж үзсэн.

С.Рэй Жеффери 1971 онд “Хэрэглэн буй орчны загвараар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” гэсэн бүтээлээрээ гэмт хэрэгтэн гэхээсээ илүүтэй гэмт хэрэг, зөрчил гарч буй тухайн орчинд төвлөрсөн нь криминологийн сэтгэлгээнд шинэ үзэл баримтлалыг бий болгосон. Үүрээр хэлбэл, анх “Crime prevention through Environmental Design” буюу CPTED гэсэн нэр томьёог ашигласан хүн юм.

Архитектор Оскар Ньюман 1972 онд “Хамгаалагдсан орон зай: Хотын загварчлалаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь²” бүтээлээрээ криминологич Жеффриг дэмжиж, нутаг дэвсгэр, хяналт тавих боломжуудыг бий болгон, дотоод, гадаад аюулгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн бүтээлийг гаргажээ.

Сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр олон судлаачид хувь нэмэр оруулсан бөгөөд тэдний дунд Рональд Кларк, Паул, Патриция Брантингем, Маркус Фелсон, Тимоти Д Кроуг нар байв. Ийнхүү улс орнуудад энэ чиглэлийн судалгаа хийгдэж, олон тооны барилга байгууламжид туршилт хийгдэж байв. Харин дотоодын судлаачдаас Г.Оюунболд “Гэмт явдалын суурь шалтгаан, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт илтгэлд “гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэрэглэн буй орчныг загварчлах” талаар товчхон дурсан бол судлаач Г.Бямбадорж “Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд орчны нөхцөлийг үнэлэх онол загварыг ашиглах нь³” сэдвээр илтгэл, үгүүлэл бичигдсэн байна.

Орчны загварчлалаар гэмт хэрэг, зөрчлөх урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй нөхцөл байдлыг газар нутаг, байршил зэрэг тухайн орчны зураг төсөлд тусгаж, урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх явдал юм⁴. Энэ нь англи хэлэнд “*Crime Prevention Through Environmental Design*” гэж нэрлэгддэг бөгөөд бид цаашид энэ үгийн товчилсон хэлбэр болох CPTED гэж энэхүү үгчиллэгт хэрэглэнэ.

¹ <https://www.police.qld.gov.au/sites/default/files/2018-08/CPTEDPartA.pdf>

²

Newman, O. (1972). *Defensible space: Crime prevention through urban design*. New York: Macmillan.

³ Бямбадорж Г. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд орчны нөхцөлийг үнэлэх онол загварыг ашиглах нь. Цагдаа судлал сэтгүүл.

⁴ Steven P. Lab. *Crime prevention: approaches, practices, and evaluations*. 2016.p 56.

Профессор Ньюмен хамгаалагдсан орон зайн онолыг санал болгодог¹ бөгөөд нийгмийн байгууламжийн биет илэрхийллээр гэмт хэрэг, зөрчил үйлдэх нөхцөл байдлыг багасгах загвар юм. Өөр хэлбэл, тухайн газар нутгийн биет шинж чанар нь оршин суугчид болон гэмт хэрэг, зөрчил гаргагчдын зан төлөвт нөлөөлөх боломжтой гэсэн санаа юм. Оршин суугчдын хувьд тухайн газрын гадаад нэмж, дизайн нь оршин суугчид бие биедээ ойртох боломжийг бөрдүүлэхээс гадна газар нутгийн ашиглалтыг сайжруулж, гэмт хэргийг хянах, устгахад хувь нэмрээ оруулах боломжтой гэж үздэг.

Хүснэгт №01. Орчны загварчлалаар урьдчилан сэргийлэх ажлын 4+3

элемент

Нутаг дэвсгэрийн Тухайн нутаг дэвсгэр дээр ямар нэг зүйл буруу хамгаалалт-Territoriality болоход хүмүүсийг тодорхой арга хэмжээ авахыг уриалдаг

Тандалт /байгалийн Тусгай төхөөрөмжийн тусламжгүйгээр тандалт/- Natural гадаах үйл явдлыг ажиглах боломжтой байх Surveillance

Гадаад төрх - Image Оршин суугчид тухайн байрныхаа гадаад төрхөд анхаарч, арга хэмжээ авах Milieu Гэмт хэрэг хамгийн бага байхаар том талбайд байшин, барилгыг барьж, байрлуулах

Бусад элементүүд

Нэвтрэхэд хяналт тавих Хууль ёсны хэрэглэгчдэд нэвтрэх боломжид хяналт тавих эсхүл орж гарч байгаа хүн бөрийг бөртгэгдэхээр зохицуулсан байх



Үйл ажиллагааг дэмжих Иргэд болон бусад хууль ёсны хэрэглэгчид хоорондын харилцан үйлчлэлийг сайжруулахад чиглэсэн чиг үүрэг

Зорилтот хамгаалалт- Гэмт этгээдийн гэмт үйлдлээ хэрэгжүүлэхэд Target Hardening маш их хүчин чармайлт гаргахад хүргэхээр нөхцөл байдлыг өөсгөх

Дээрх хүснэгтээр профессор Ньюмэний “хамгаалагдсан орон зайн” онолын дөрвөн элементийг үзүүлсэн бөгөөд “нутаг дэвсгэрээ хамгаалах”, “тандалт, хяналт”, “гадаад төрх” /дүрс, зураг/, “Milieu” зэргийг тодорхойлжээ. Эдгээр дөрвөн элементээс гадна “CPTED”-д дэмжлэг үзүүлэх бусад элементийг хамааруулсан. Үүнд: “хандалтын хяналт”, “зорилтот хамгаалалт”, “үйл ажиллагааг дэмжих” зэрэг элементүүдийг нэмж оруулсан.

Newman, O. (1972). *Defensible space: Crime prevention through urban design*. New York: Macmillan.

Нэг. Байгалийн тандалт¹. Энд гэмт хэрэг, злрчил гаргаж болзошгй этгээддийг ажиглах боломжийг нэмэгдлдэг аливаа йлдэл, боломжийг




хамааруулдаг байна. рр хэлбэл, оршин суугчид болон хууль ёсны хэрэглэгчид нь хрээлэн буй орчиндоо юу болж байгааг харж,

ажиглах боломжтой байх (албан бус тандалт гэж нэрлэдэг) ёстой.

Мн барилгын хаалгыг хэд хэдэн оршин суугчид хамтдаа хэрэглэх, бие биеэ таних, ойр орчмын айлуудын йл явдлыг харах боломжийг олгоно гэж здэг. Тухайн барилга байгууламжийн доторх болон эргэн тойрон дахь замууд нь оршин суугчдыг байшин руугаа орох, гарах нхцлийг саадгй байлгах тал дээр анхаарч зэх ёстой юм.

Энэх тандалт нь гэмт хэргийг бууруулахад шууд нлллх ёстой. Гаднах орчинд хяналт тавих боломжтой хмсийн тоо нэмэгдэхийн хэрээр гэмт хэрэг йлдэх, хяналтгй байдлаас гарах боломжтой юм. ний р днд гэмт хэрэг йлдэх сэжиг бхий этгээд илэрвэл ажиглагчид цагдаад мэдэгдэж, гэмт хэргийг арилгахад чиглэсэн бусад арга хэмжээ авах боломж брдэх юм.

Хоёр. Нутаг дэвсгэрийн хамгаалалт. Энд тухайн газар нутагт хязгаарлалтыг хийснээр оршин суугч болон бусад хмст хил хязгаарыг ойлгомжтой болгодог. Хамгийн гол нь оршин суугчид болон хууль ёсны хэрэглэгчид, тнчлэн гэмт этгээд тухайн газрын хамгаалалтын талаар мэдлэгтэй болсноор халдлагаас хамгаалах эсхл гэмт санаа бодлоос татгалзах шийдвэр гаргах нхцл брддэг.



¹ Crime Prevention Through Environmental Design.

<https://www.chandlerpd.com/wp-content/uploads/2010/12/Chandler-C3-CPTED-Handbook-2016-1.pdf>


Козенс, Савилле нарын эрдэмтэд нутаг дэвсгэрийн хамгаалалтын хоёр хэлбэрийг авч үздэг. Энэ нь бэлгэдлийн болон бодит хэлбэртэй хамгаалалт гэж ангилсан¹.

Бэлгэдлийн хамгаалалттай нутаг дэвсгэрт тэмдэг, тэмдэглэгээ, тохижилт (мод бургасаар хийсэн тохижилт) эсхүл нмчллийг харуулсан бусад таних тэмдэг гэх мэт зүйлийг ашигласнаар хамгаалалтын хэлбэрийг илэрхийлдэг бол нутаг дэвсгэрийн бодит хамгаалалт нь хана, хашаа, хаалга, бусад эд зүйлээр тухайн газар нутаг эсхүл нмчллийг илтгэх хэлбэртэй байна².


Гурав. Дүр тгрх ба Milieu. Энэ нь тухайн газар, нутгийн иргэд өөрийн нмчид хяналт тавьж байгаа гэдэг мэдээллийг гэмт этгээдэд нгч байдаг гэсэн утга илэрхийлнэ. Энэхүү үзэл санаанд хрээлэн буй орчноо сайн арчилж тордох нь гэмт хэрэг, зрчил гарах нхцлийг багасгах, урьдчилан сэргийлэх боломжийг брдүүлнэ гэж үздэг. Тиймээс гэмт хэрэг, зрчил багатай бсэд барилга байгууламж, бизнес, шинэ нийгэмлэг байгуулах нь тухайн объектод чухал ач холбогдолтой.

Дүрв. Нэвтрэхэд хяналт тавих ба зорилт хамгаалалт. Эдгээр хоёр элемент нь гэмт хэрэгтэн, зрчил гаргагчийг гэмт хэрэг үйлдэхэд нь саад учруулахад чиглэдэг байна. Нэвтрэхэд хяналт тавих нь зүвхн тухайн хэсэгт албан ёсны нэвтрэх зүвшнрүлтэй хмүүлст л нэвтрэх боломжийг олгодог. Энэ хяналтыг хршийн хяналт болон олон нийтийн түвшинд ч ашиглаж болно. Энэхүү хяналтын хрээнд нийтийн эзэмшлийн хэсэгт хаалга, замын хаалт хийх, танихгүй хмүүлсийг тухайн бс нутгаар дамжин нгүрх хдүлгүүнийг хязгаарлах, оршин суугчдыг таних боломжтой болгох зэргээр хяналтыг явуулж болно.

Зорилтот хамгаалалт. Энэ нь нэвтрэхэд хяналт тавих элементтэй нягт холбоотой бгүүд хаалганы цоож, цонхны тавцан, шил, хашаа, сейф зэрэг нь эвдрэхгүй, хагарахгүй, дохиололтой байснаар гэмт хэрэг үйлдэхэд хндрэл



Security Door Viewer



Traditional Peephole



учруулдаг. Мн хулгайлсан барааг хашаа даван авч явахад илүү хэцүү болгож, хохирогчид олж тогтооход хялбар болгодог тул таних тэмдэг байрлуулах замаар гэмт хэргийг хянах шууд бус арга хэлбэрийг ашиглаж болно.

¹ Cozens, P.M., G. Saville and D.Hillier (2005) *Crime prevention Through environmental design (SPTED): A review and modern bibliography*. *Property management* 23:328-356

² P Michael Cozens, G Saville, D Hillier. *Crime Prevention through Environmental Design (CPTED): A Review and Modern Bibliography*

Зургаа. Оршин суугчдын Үйл ажиллагааг дэмжих, сэдлийг нэмэгдүүлэх. Энд оршин суугчдын Үйл ажиллагааг дэмжих, сэдлийг нэмэгдүүлэх нь хамт олны уур амьсгалыг бий болгохтой холбоотой юм. Үүрх хэлбэл, энэ үзэл баримтлал нь оршин суугчдын дунд нийгмийн эв нэгдлийг нэмэгдүүлэх талаар авч үздэг юм.

Гэмт хэрэг, зөрчил болон бусад нийтлэг бэрхшээлийг арилгахад чиглэсэн нийтийн уур амьсгалыг бий болгох ажиллагаанд гудамжны үзэсгэлэн худалдаа гаргах, олон нийтийн дүрлэг зохион байгуулах, болон бусад нийгмийн арга хэмжээг зохион байгуулдаг.



Орчны загварчлалаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Үйл ажиллагааг 1990-ээд оны дунд үеэс эхлэн олон нийтэд танилцуулж, хэрэгжүүлэх чиглэлээр томоохон зохион байгуулалттай хөдөлгөөн үргэлжлэн бөгөөд АНУ-аас гадна Англид Цагдаагийн ахлах офицеруудын холбоо (ACPO) нь “Secured By Design”¹ буюу “Аюулгүй байдлын загвар” (SBD) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөр нь (Замын цагдаагийн газар, Гэмт хэрэгтэй тэмцэх газрын удирдлагын хөрөнд) одоо байгаа барилгад аюулгүй байдал, аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэхийг онцлон дэмждэг байна. “SBD” хөтөлбөр нь хэссэн аливаа байгууллагад архитектур, аюулгүй байдлын туслалцаа үзүүлдэг.

CPTED-ийн Үйл ажиллагаа нь зөвхөн Засгийн газраас бус орон нутгийн засаг захиргаа эсхэл хувийн, мэргэжлийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэх чиг үүрэгтэй юм. Эдгээрийн дотор Олон улсын CPTED холбоо, CPTED аюулгүй байдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Үндэсний зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Үндэсний хөрөөлөнгийн сургалтын вэбсайт, Гэмт хэрэгтэй тэмцэх дизайн гаргах Үндэсний холбоо (United Kingdom)-ууд Үйл ажиллагаа хэрэгжүүлж байдаг.

НҮБ-ын Бүсийн Гэмт хэрэг, шударга ёсны судалгааны хөрөөлөнгээс (UNICRI) "Хотын аюулгүй байдлыг ногоон орчны зураг төслөх сайжруулах нь" судалгааг 2011 онд нийтлүүлэв. Энэхүү баримт бичиг нь олон нийтийг оролцоог сайжруулж, гэмт хэрэг болон бусад нийгмийн асуудлыг багасгахад чиглэсэн ногоон тогтвортой загварыг ашигладаг гурав дахь үеийн CPTED-ийг санал болгож байна.

Гурав дахь үеийн CPTED нь "Хотын орон зайг аюулгүй гэж ойлголтыг бий болгодог практик арга хэмжээ авахыг шаарддаг бөгөөд дөрвөн том бүрэлдэхүүн хэсгийг багтаасан. Үүнд: 1) газар; 2) хүн; 3) технологи; 4) сэлжээ. CPTED-ийн энэ хувилбар нь хотын аюулгүй байдлыг хангах үүднээс орон зайг дахин программчлах зорилготой юм.


¹ <https://www.securedbydesign.com/>

place – газар	Аюулгүй гэр, аюулгүй байдлын ажилчид, идэвхтэй төвүүд, шинэ хөгжил, эрүүл орчин, байгалийн ажиглалт, нийтийн боловсрол,
people – хүмүүс	хүмүүсийн сонсох чадвар, харилцаа холбоо, холбоотой мэт мэдрэмж, олон нийтийн цуглаан
technology – технологи	эрчим хүчний үр ашиг, ил тод байдал, ногоон энерги, тандалтын сүлжээ, мэдээлэл зүй, бодит цагийн өөрчлөлт, харилцан үйлчлэл, кибернетик
networks – сүлжээ	Олон нийтийн физик харилцаа, эрчим хүч, харилцаа холбоо, wireless сүлжээний мэдээллийн дамжуулалт

Дээрх х[снэгтэд] з[лсэн] н[дсэн] б[рэлдэх]н хэсэг б[р] нь хэрэглэгчдийн хоорондын харилцан үйлчлэл, аюулг[й] байдлыг нэмэгд[лэхэд] чиглэсэн х[чин] чармайлтыг бий болгодог. Энэ б[хний] н[дэс] суурь нь тогтвортой нийгэмд технологи болон ногоон дизайныг ашиглах явдал юм.

Дээрх онолын судалгааны х[рээнд] Улаанбаатар хотын орон сууцны нэг хотхоны н[хц]л байдлыг хийлээ. Энэх[д] ажлын х[рээнд] Баянз[рх] д[ргийн] 26 дугаар хороонд байрлах Олимп Виллаж хотхоныг судлан [зэхэд] 500 [рх] айл оршин суудаг, 12 давхар 2 орон сууц, орон сууцны дунд х[хдийн] тоглоомын талбай, мод з[лэгж]лэлт, усан оргилуур, оффис 2 давхар барилгатай, явган болон авто машины замтай байхаар т[л]вл[н] барьжээ.

Зургаас харахад энэх[д] объект нь машинаар болон явганаар орох, гарах гарц нэг т[в] хаалгатай, 30 камертай, харуул хамгаалалттай байна. Эндээс харахад CPTED-ийн онолын



загвар, хэлбэр хотхоны тохижилтод байгаа эсэхийг [зэхэд] н[дсэн] 4 болон нэмэлт 3 элементийн зарим хэсгийг багтаасан байна. [хнийг] дараах х[снэгтээр] з[лбэл]:

Элемент	Үнэлгээ				
	1	2	3	4	5
Нутаг дэвсгэрийн хамгаалалт – Territoriality			+		
Тандалт, шалгалт /байгалийн тандалт/- Natural Surveillance				+	
Гадаад төрх, зураг – Image Milieu		+			
Нэмэлт элемент					
Нэвтрэхэд хяналт тавих			+		
Үйл ажиллагааг дэмжих				+	
Зорилтот хамгаалалт-Target Hardening		+			

Орчны загварчлалаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Олимп виллаж хотхонд хэрэгжүүлж буй байдлыг ажиглахад тухайн онолыг шууд хэрэглээгүй боловч оршин суугчдын аюулгүй, гэмт хэрэг, зөрчлөс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тодорхой хэмжээнд авч хэрэгжүүлсэн байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт

Эрдэмтэн судлаачид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай асуудлыг нийгэм, эдийн засаг, нутаг дэвсгэр, хүн ам, зан заншил, соёл иргэншилд тулгуурлаж зохион байгуулдаг байсан бол энэхүү урьдчилан сэргийлэх ажлаас хэрэглэн буй орчинтой харилцах асуудалд илүү анхаарал хандуулан авч үзсэн нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, орчны загварчлалаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголтод тулгуурлаж, барилга байгууламжийн зураг төсөл, хот тосгоны төлөвлөлттэй уялдуулж, энэхүү арга хэмжээг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна.

Монгол Улсад гэмт хэрэг, зөрчлөс урьдчилан сэргийлэх нь арга хэмжээг орчин өөрийн хөгжил, дэвшил, нийгмийн онцлогтой уялдуулан цоо шинэ арга барилаар зохион байгуулах шаардлагатай болжээ. Сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь зөвхөн ухуулга, сурталчилгаа хийх, телевиз, радиогоор нэвтрүүлэг хийх зэргээр л хийгдсэн байна. Мөн гэмт хэргийн нөхцөл байдал ихээхэн хувьсал, зөрчлөлт гарч байгаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтолцоогоор нь шинэчлэх, практикт хэрэгжүүлэх, хангах арга замыг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг нь хууль эрх зүйн оновчтой тогтолцоо, төрийн бодлогын бодит дэмжлэгээр дамжин сайжруулах, иргэн хөрөнний нэгдсэн бодлого боловсруулах, улмаар төнд нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй

хэрэгцээ, шаардлага байгааг мэдэслэн энэхүү судалгааны ажилд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Орчны загварчлалаар гэмт хэрэг, зөрчлөх урьдчилан сэргийлэх ажлын гарын авлага боловсруулах. Энэхүү ажлыг улсын хэмжээнд Нутгийн төрөө удирдах байгууллага, Засаг даргын тамгын газар, хот (аймаг, бусад суурин газар) төлөөлөлт хариуцсан байгууллага (Барилга, хот байгуулалтын яам, Төх К гэх мэт)-тай хамтран хэрэгжүүлэх;

2. CPTED энэ чиглэлээр баригдаж буй барилга байгууламжийг шалгах хуудсыг боловсруулах;

3. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөх урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч нарт орчин үеийн шинэ арга хэлбэр, дэвшилтэт техник, технологи ололт, амжилт, удирдлагын менежмент, инновацийн шинэ санааг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хэрхэн ашиглах талаар сургалт семинар зохион байгуулах;

Эх сурвалжийн жагсаалт

[1] <https://www.police.qld.gov.au/sites/default/files/2018-08/CPTEDPartA.pdf>

[2] Newman, O. (1972). Defensible space: Crime prevention through urban design. New York: Macmillan.

[3] Бямбадорж Г. Гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаанд орчны нөхцөлийг нэлэх онол, загварыг ашиглах нь. Гэмт явдалтай тэмцэх асуудалд. 2017 №01.

[4] Steven P. Lab. (2016) Crime prevention: approaches, practices, and evaluations.

[5] Newman, O. (1972). Defensible space: Crime prevention through urban design. New York: Macmillan.

[6] Crime Prevention Through Environmental Design.

[https://www.chandlerpd.com/wp-content/uploads/2010/12/Chandler-C3-CPTED-Handbook-2016-1 .pdf](https://www.chandlerpd.com/wp-content/uploads/2010/12/Chandler-C3-CPTED-Handbook-2016-1.pdf)

[7] Cozens, P.M., G.Saville and D.Hillier (2005) Crime prevention Through environmental design (CPTED): A review and modern bibliography. Property management 23:328-356

[8] P Michael Cozens, G Saville, D Hillier. Crime Prevention through Environmental Design (CPTED): A Review and Modern Bibliography

[9] <https://www.securedbydesign.com/>